

9

МОНГОЛ УЛСЫН ДААТГАЛЫН ЗАХ ЗЭЭЛИЙН ӨНӨӨГИЙН БАЙДАЛ

Г.Бурмаа

Зах зээл өндөр хөгжсөн түүхэн туршлагаас аливаа бизнесийн үйл ажиллагааг даатгалгүйгээр төсөөлөх аргагүй. Ялангуяа нийгэм хөгжиж зах зээлийн харилцаанд гүнзгий орох тусам үйлдвэр аж ахуйн нэгжүүд харилцан бие биенээс хараат болж үйлдвэрлэлийн нийгмийн шинж чанар хүчтэй болсноос аль нэг нэгжид учирсан хохирол нөгөөд нөлөөлж хохирлын гинжин хэлхээ үүсдэг байна. Үүнээс гарах арга зам бол нэгж бүр даатгалын сангийн гишүүн болж санг бүрдүүлэхэд оролцох явдал юм. Даатгалын эдийн засгийн агуулга нь аль нэг нэгжид учирсан хохирлыг нийгмийн нийт гишүүдийн дунд хуваарилах явдал байдаг ба даатгалын сан байгуулах гол зарчим нь хохирогчийн тоо даатгуулагчийн тооноос ямагт бага байх магадлал өндөр байдагт түшиглэдэг болно.

Орчин үед даатгалын үйл ажиллагаа нь өмч хөрөнгөөс авахуулаад хүний амь нас, эрүүл мэнд, амьдрах баталгаат байдал, бизнесийн орлого, ашиг, хариуцлага, дампуурлыг хүртэл хамрах болжээ.

Даатгал өндөр хөгжсөн АНУ, Япон, Герман, Англи, Франц зэрэг орнуудад даатгалын орлого дотоодын нийт бүтээгдэхүүний 10-12 хувийг эзэлдэг бол манай оронд 0.4-0.5 хувийг эзэлж, даатгалын зах зээлийн хамралт, цар хүрээ нь маш хангалтгүй байгааг харуулж байна. Нөгөө талаар даатгалыг нийгмийн баталгаат хамгаалалт бүрдэх хүртэл ажиллах өргөн боломж байгааг харуулж байна.

Одоогийн байдлаар төрийн өмчийн 2 (Монгол даатгал, Түшиг даатгал), хувийн өмчийн 15 даатгалын компани арилжааны даатгалын үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл авч ажиллаж байна.

**Даатгалын зах зээлийн бүтцийн судалгаа
(2000 оны жилийн эцсийн байдлаар)
/хувиар/**

№	Даатгалын төрөл	Монгол даатгал	Түшиг даатгал	Д энд Б даатгал	Ажнай инш ре	Ми энд Р	И Би Эйч Бодь даатгал	АЙТи Си Дат даатгал	Ард даатгал	Торгон зам даатгал	Эрэл даатгал	Дүн
1	Амь нас, эрүүл мэнд, ашиг сонирхлын даатгал	69.0	0.4	0.0	1.5	0.0	20.7	1.2	3.2	3.4	0.5	100
2	Эд хөрөнгийн даатгал	75.8	1.0	0.0	0.1	3.0	1.3	1.1	4.0	3.4	10.3	100
3	Хариуцлагын даатгал	80.7	2.2	10.2	0.9	2.2	0.5	0.8	1.0	1.5	0.0	100

Даатгалын зах зээлийн байдлыг судалж үзэхэд Монгол Даатгал компани амь нас, эрүүл мэнд болон ашиг сонирхлын даатгалын 69.0%, эд хөрөнгийн даатгалын 75.8%, хариуцлагын даатгалын 80.7%-ийг эзэлж байна.

Эндээс дүгнэн үзэхэд манай улсын даатгалын зах зээлийн дийлэнхийг Монгол Даатгал компани хяналтандаа байлгасаар байна.

Хувийн даатгалын компаниудын хувьд авч үзэхэд амь нас, эрүүл мэнд болон ашиг сонирхлын даатгалын зах зээлийн 20.7%-ийг "Бодь компани" эзэлж Монгол даатгал компаний дараа орж байна. Эд хөрөнгийн даатгалын зах зээлийн 10.3%-ийг "Эрэл даатгал" компани, хариуцлагын даатгалын зах зээлийн 10.2%-ийг "Д энд Б" даатгал компани тус тус эзэлж байна. Судалгаанаас үзэхэд нийт даатгалын зах зээлийн 10% орчим нь бусад даатгалын компаниудад ноогдож байна.

Даатгалын нэр төрлийн бүтцийн байдлыг авч үзэхэд компаниудын дүнгээр:

- Амь нас, эрүүл мэнд болон ашиг сонирхлын даатгал 9.9%
- Эд хөрөнгийн даатгал 61.5%
- Хариуцлагын даатгал 28.6 хувийг тус тус эзэлж байна.

Бүтцийн дээрх байдал Монгол даатгал, Түшиг даатгал, Торгон зам даатгал компанид хадгалагдаж байна. И Би Эйч Бодь даатгал компанийн эрхэлж буй даатгалын 68.4%-г амь нас, эрүүл мэнд болон ашиг сонирхлын даатгал эзэлж байгаа юм.

**Даатгалын компаниудын эрхэлж буй даатгалын төрлийн
бүтцийн судалгаа (2000 оны жилийн эцсийн
байдлаар, хувиар)**

№	Даатгалын төрөл	Монгол даатгал	Түшиг даатгал	Д энд Б даатгал	Ажнай инш ре	Ми энд Р	И Би Эйч Бодь даатгал	АЙТи Си Дат даатгал	Ард даатгал	Торгон зам даатгал	Эрэл даатгал
1	Амь нас, эрүүл мэнд, ашиг сонирхлын даатгал	8.9	3.4	0.0	33.1	0.0	68.4	11.4	10.3	11.8	0.7
2	Эд хөрөнгийн даатгал	60.9	46.4	0.0	10.1	74.5	26.5	66.4	80.3	73.0	99.3
3	Хариуцлагын даатгал	30.2	50.2	100.0	56.8	25.5	5.1	22.2	9.4	15.1	0.0
Нийт		100%	100%	100%	100%	100%	100%	100%	100%	100%	100%

**Даатгалын хураамжийн орлогын бүтэц
(сая. төг)**

	1999		2000	
	Орлого	Хувь	Орлого	Хувь
Монгол даатгал	2447.8	76.9	2891.4	76.6
Бусад даатгалын компаниуд	736.4	23.1	885.2	23.4
Нийт	3184.2	100	3776.6	100

Даатгалын хураамжийн орлогын хувьд 2000 онд даатгалын компаниуд 3.8 тэрбум төгрөгийн хураамжийн орлоготой ажилласны 76.6%-ийг Монгол даатгал компани дангаараа бүрдүүлжээ.

Даатгалын хураамжийн нийт орлогын 69%-ийг аж ахуйн нэгж байгууллагууд, 31%-ийг иргэдээс оруулсан байна. 2000 онд даатгалын компаниудын дүнгээр 751.1 сая төгрөгийн нөхөн олговор олгосон нь хураамжийн орлогын 20.2%-ийг эзэлж байна.

Даатгал хөгжсөн орнуудын энэ үзүүлэлт 60-70% байдагтай харьцуулахад хангалтгүй байгаа юм. Хохирол нөхөлтийн бүтэц компани бүрт харилцан адилгүй байна. Тухайлбал, амь нас, эрүүл мэнд болон ашиг сонирхлын даатгалын хохирол нөхөлт Ай Ти Си Дат даатгал компанид 53.0%, Монгол даатгал компанид 48.1%, эд хөрөнгийн даатгалын хохирол төлөлт Түшиг даатгал компанид 34.4%, хариуцлагын даатгалын хохирол төлөлт Монгол даатгал компанид 22.4% байгаа нь бусад компаниудаас өндөр байна.

Даатгалын хураамжийн орлого, хохирол нөхөлтийн үндсэн үзүүлэлтүүд даатгалын компаниудын хувьд дээрх байдалтай боловч хамгийн гол үзүүлэлт болох даатгалын

хамралт туйлын хангалтгүй байгаа юм. Даатгалын хамралт нэмэгдэж, даатгуулагчийн тоо өсөх тусам даатгалын үйл ажиллагаа улам бүр өргөн далайцтай, үр өгөөжтэй байх ёстой.

Даатгалын хураамжийн орлого, үйлчлүүлэгч даатгуулагчийн тооцоогоороо тэргүүлж, Монгол улсын даатгалын зах зээлийн 80 орчим хувийг хяналтандаа байлгадаг Монгол даатгал компанийн тухайд авч үзэхэд энэ үзүүлэлт туйлын хангалтгүй байгаа нь харагдаж байна. Тухайлбал, амь нас, эрүүл мэнд болон ашиг сонирхлын даатгалаас манайд хамгийн өргөн тархсан гэнэтийн осол болон хөдөлмөрийн чадвар алдалтын даатгалын тухайд авч үзэхэд даатгалын хамралт дөнгөж 5.3 хувьтай байна. Бусад компаниудыг оруулж тооцлоо гэхэд нийт хүн амын 90 гаруй хувь нь даатгалын хамгаалалтгүй явж байна гэсэн үг. Эд хөрөнгийн гол нэр төрөл болох иргэдийн эд хөрөнгийн даатгалын хувьд авч үзэхэд статистик мэдээгээр 535.3 мянган өрх байгаа боловч дөнгөж 30500 ширхэг цахилгаан хэрэгслээ даатгуулжээ. Хамралт хамгийн өндөртэй тээврийн хэрэгслийн даатгалын тухайд 55.6 хувийн хамралттай байна. Үлдсэн хувийг хувийн даатгалын компаниуд хуваарилан авдаг боловч даатгалын үнэлгээ нь 2-3 дахин доогуур тогтоогддог практик бий болжээ. Онцгой анхаарал татсан даатгалын нэг болох малын даатгал өнөөдрийн байдлаар бараг тэглээд байгаа нь сэтгэл эмзэглүүлсэн асуудал болж байна.

Монголын арилжааны даатгалын анхны байгууллага 70-аад жилийн өмнө байгуулагдсан хэдий ч арилжааны даатгалын зохицуулалтын бие даасан хууль тогтоомж нь харьцангуй сүүлд батлагдсан учраас энэ салбарын эрх зүйн таатай орчин хараахан бүрдэж гүйцээгүй байна. Энэ чиглэлээр сурч боловсорсон боловсон хүчин дутагдалтай, мэдээлэл судалгаа төдийлөн хийгдээгүй, ялангуяа хохирлын талаарх статистик судалгаа байдаггүй нь тарифыг тооцоход хүндрэл учруулдаг. Зах зээлд хэдийчинээ эрүүл саруул өрсөлдөөн байна, төдий хэмжээний хөгжих боломж бүрддэг боловч даатгалын компани шинээр байгуулагдах шалгуур, шаардлагыг өндөрсгөж, менежмент хүчин чадал сайтай компанийг дэмжих явдал чухал асуудал юм. Одоогийн байдлаар даатгалын компаний дүрмийн сангийн хэмжээг 100.0 сая төгрөгөөр тогтоосон нь даатгуулагчийн хохирлыг нөхөн төлөх баталгаа болох боломжгүй юм. Энэ нь нэг томоохон аж ахуйн нэгжийн хөрөнгө сүйдэхэд даатгалын компани дампуурах боломжийг бүрдүүлж байна гэсэн үг юм.

Дүрмийн сангийн хувьд Монгол даатгал компани 2.7 тэрбум төгрөг, Эрэл даатгал компани 1.0 тэрбум төгрөг байгаа нь хамгийн дээд хэмжээ болж байна. Эндээс харахад Монгол даатгал компанийг задлах биш, жижиг компаниудыг нэгтгэж хүчин чадлыг сайжруулах шаардлагатай байна. Харин зах зээлийн орнуудад хамгийн өргөн дэлгэр тархсан хувьцаат компанийн хэлбэрээр зохион байгуулах боломжтой юм. Зах зээлийн эдийн засгийн зохицуулалтын арга хэрэгслийн нэг болох даатгалын үйл ажиллагааг амжилттай явуулах, түүний тогтолцоог боловсронгуй болгохын тулд дараах асуудлуудыг яаралтай шийдвэрлэх нь зүйтэй гэж үзэж байна.

1. Даатгалын компаний дүрмийн сангийн доод хэмжээг нэмэгдүүлэх замаар даатгалын компаниудыг томруулах арга хэмжээ авах, даатгалын компани байгуулах шалгуур үзүүлэлтийг боловсронгуй болгох

2. Даатгалын зах зээлийн багтаамжийг тооцон гаргах, даатгалын бүх талын үйлчилгээг үзүүлж чадах дотоод, гадаадын даатгалын компани бий болгох
3. Даатгалын нөөцийн санг хөрвөх чадвартай болгох, түүнийг депозит болгох, үнэт цаас бонд худалдан авах замаар эргэлтэнд оруулах нөхцлийг бүрдүүлэх
4. Санхүүгийн эрсдэл, орлого буурахаас хамгаалах даатгалын төрлийг шинээр бий болгох, төрөөс дэмжих, даатгалын төрөлжүүлсэн болон хосолсон байдлаар явуулах тогтолцоонд шилжүүлэх
5. Даатгалын ерөнхий хуулийг боловсронгуй болгох, даатгалын салбар хуулиуд ялангуяа малын даатгалын тухай, газар тариалангийн даатгалын тухай хуулиудыг боловсруулж яаралтай батлан гаргах шаардлагатай байна.